



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН ЯАМ

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,
Утас: 26-22-27, Факс: (976-11) 323589
E-mail: info@mecss.gov.mn, http://www.mecss.gov.mn

Г АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН
БОЛОВСРОЛ, СОЁЛ,
УРЛАГИЙН ГАЗРЫН
ДАРГА НАРТ

2020. 01. 08 № 2/78
танай _____ -ны № _____ -т

Г Тушаал хүргүүлэх тухай

Томуу, томуу төст өвчний дэгдэлт нэмэгдэж байгаатай холбогдуулан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох, сурагчдын улирлын амралтын үргэлжлэх хугацааг сунгах асуудлыг шийдвэрлэж өгөх саналыг аймаг, нийслэлийн Засаг дарга нараас тус яаманд ирүүлж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн хуралдаанаар томуу, томуу төст өвчний нөхцөл байдлын талаар хэлэлцэж, нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хоёрдугаар улирлын амралтын үргэлжлэх хугацаанд зохицуулалт хийх чиглэлийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд өгсөн.

Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хуулиар хичээлийн жилийн эхлэх, үргэлжлэх, дуусах болон сурагчдын амралтын хугацааг өөрчлөх, хичээлийг түр хугацаагаар хаах бүрэн эрх зөвхөн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд олгогдсон байдаг.

Томуу, томуу төст өвчний дэгдэлтэй холбогдуулан хууль тогтоомжид заасан хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалт, онцгой дэглэм тогтоох зайлшгүй нөхцөл үүссэн тохиолдолд асуудлыг орон нутагт шуурхай шийдвэрлэх зорилгоор цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааг түр хугацаагаар хаах, сурагчдын амралтын хугацааг өөрчлөх зохицуулалт хийх зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт олгох шийдвэрийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд 2020 оны 1 дүгээр сарын 7-ны өдөр гарсаныг Та бүхэнд үүгээр хүргүүлж байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын дээр дурдсан шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан аймаг, нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газар дараах асуудалд анхаарч ажиллана уу.

1. Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан тушаалыг аймаг, нийслэлийн Засаг даргад албан ёсоор танилцуулах арга хэмжээ авах;

2. Цэцэрлэгийн үйл ажиллагааг түр хугацаагаар хаах, сурагчдын улирлын амралтын хугацааг сунгах зайлшгүй нөхцөл үүссэн болох нь орон нутгийн онцгой комиссын санал, дүгнэлтээр нотлогдсон тохиолдолд шийдвэр гаргахыг Засаг даргад уламжлах;

3. Ерөнхий боловсролын сургуулийн сургачдын хоёрдугаар улирлын амралтын хугацааг үүссэн нөхцөл байдалтай уялдуулан сунгах тохиолдолд 7 хоногийн хугацаагаар сунгаж, 2019-2020 оны хичээлийн жилийн гуравдугаар улирлын хичээлийг 2020 оны 1 дүгээр сарын 20-ны өдрөөс хэвийн эхлүүлэх;

4. Сургачдын хоёрдугаар улирлын амралт сунгасан хугацаанд томуу, томуу төст өвчний дэгдэлт холбогдох мэргэжлийн байгууллагын мэдээгээр ихэссэн, цаашид сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн хаах зайлшгүй нөхцөл үүсэх тохиолдолд сургачдын гуравдугаар улирлын хоёр 7 хоногийн амралтын нэг 7 хоногийг шилжүүлэх зохицуулалт хийх. Энэ тохиолдолд сургачид гуравдугаар улирлаар 7 хоног амрах болохыг багш, сургачид, эцэг эх, асран хамгаалагчдад мэдээлж ойлгуулах;

5. Цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох шийдвэр гаргах зайлшгүй нөхцөл үүсэн тохиолдолд тус яамны Сургуулийн өмнөх боловсролын бодлогын газар, Ерөнхий боловсролын бодлогын газарт урьдчилан мэдэгдэж, шийдвэрийг тушаалд заасан хугацаанд Сургуулийн өмнөх боловсролын бодлогын газрын мэргэжилтэн Ц.Сарантуяа, Ерөнхий боловсролын бодлогын газрын мэргэжилтэн Ц.Чимэдлхам нарт цахим шуудангаар ирүүлэх;

6. Хичээл, сургалтын үйл ажиллагааг түр хугацаанд зогсоосон хугацаанд барилга байгууламжийн цахилгаан, дулаан хангамжийн хэвийн ажиллагаа доголдоогоос урьдчилан сэргийлэх, цэцэрлэг, сургуулийн орчинд хүүхдийг хамарсан нэгдсэн зохион байгуулалттай арга хэмжээ явуулахгүй байх;

7. Томуу, томуу төст өвчний дэгдэлттэй холбогдуулан хичээлийн жилийн үргэлжлэх хугацаанд өөрчлөлт оруулахгүй бөгөөд сургачдын амралтын хугацааны хичээлийн агуулгыг нөхөх асуудлаар сургуулиудад арга зүйн зөвлөмж, удирдамж хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;

8. Томуу, томуу төст өвчлөлийн талаарх мэдээ, мэдээллийг орон нутгийн эрүүл мэндийн байгууллагаас тогтмол авч байх.

Хавсралт 1 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,
ХУУЛИЙН ХЭЛСТИЙН ДАРГА   Л.ЦЭДЭВСҮРЭН



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 07 өдөр

Дугаар 4/05

Улаанбаатар хот

Г Зохицуулалт хийх зөвшөөрөл
олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалт, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, Бага, дунд боловсролын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг, "Хичээлийн жилийн бүтэц батлах тухай" Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/490 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгаль, цаг уурын гаралтай аюулт үзэгдэл, томуу, томуу төст өвчний дэгдэлт, халдварт өвчний тархалттай холбогдуулан хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалт, онцгой дэглэм тогтоох нөхцөл үүссэн тохиолдолд ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын 2019-2020 оны хичээлийн жилийн хоёрдугаар улирлын амралтын үргэлжлэх хугацааг 7 хоногоор сунгах, өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэгийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох арга хэмжээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тус тус шийдвэрлэх, сурагчдын амралтын хугацааг дахин сунгах зайлшгүй нөхцөлд 2019-2020 оны хичээлийн жилийн гуравдугаар улирлын амралтын нэг 7 хоногийг шилжүүлэх зохицуулалт хийхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тушаалын нэг дэх хэсэгт заасан шийдвэр гарах нөхцөл үүссэн тохиолдолд Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Ням-Очир/, Сургуулийн өмнөх боловсролын бодлогын газар /Ж.Мягмар/-т урьдчилан мэдэгдэж, шийдвэрийг ажлын хоёр өдрийн дотор яаманд ирүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Сурагчдын улирлын амралтын хугацаа сунгасантай холбогдуулан сургалтын хөтөлбөр хичээлийн жилийн үргэлжлэх хугацаанд бүрэн хэрэгжсэн байх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн боловсрол, соёл, урлагийн газрын дарга нарт үүрэг болгосугай.

4. Энэ тушаалыг 2019-2020 оны хичээлийн жилд мөрдсүгэй.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын дэд сайд /Г.Ганбаяр/-д үүрэг болгосугай.



Ё.БААТАРБИЛЭГ

142010014